БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 26 өдөр Дугаар А/399 Булган

Хамтын ажиллагааны хороо байгуулах тухай

Орон нутгийн хөгжлийг дэмжих хамтран ажиллах гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн Засаг дарга болон Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Хамтын ажиллагааны хорооны гишүүдийг хавсралтаар батлсугай.

2. Хорооны үйл ажиллагааг хууль дүрмийн дагуу зохион байгуулж ажиллахыг Хорооны дарга /Б.Ууганбаяр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА З.БАТЗОРИГ

2017 оны 07 сарын 27 өдрийн ...тоот
захирамжийн хавсралт

Хамтын ажиллагааны хорооны бүрэлдэхүүн

Дарга: Б.Ууганбаяр- Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга

Гишүүд: П.Хишигдаваа- Аймгийн Засаг даргын тамгын Хууль эрх зүйн хэлтсийн дарга
Д.Батмөнх- "Өгөөж баян хангай" ХХК-ний захирал
Д.Отгон "Эвсэг сайхан" ХХК-ний захирал
Г.Батболд-"Цагаан уулын магнит" ХХК-ний захирал
Б.Маналсүрэн- Бүрэгхангай сумын Дэрст багийн Иргэн
Д.Батдорж-Дашинчилэн сумын Доргонт багийн иргэн
Д.Ганхуяг- Булган сумын иргэн

Нарийн бичгийн дарга: О.Наранжаргал- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 27 өдөр Дугаар А/400 Булган

Г

Комисс томилох тухай

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолоор батлсан "Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 3.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын Соёл, амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн үерийн хамгаалалтын далангийн засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга - Д.Буманбаяр /Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга/

Нарийн бичгийн дарга - Б.Ганчулуун /ГХБХБГ-ын мэргэжилтэн/

Гишүүд:
- М.Мөнхзул /ОБГ-ын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч ахма/
- Ц.Ариунбулган /"Өрнөх хийморь" ХХК-ний захирал/
- Л.Чимгээ /Тохижилт үйлчилгээний ангийн дарга/
- Н.Гүржав /ГХБХБГ-ын мэргэжилтэн/
- Т.Дорж /Төрийн архивын тасгийн дарга/

2. Соёл, амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн үерийн хамгаалалтын далангийн засвар, шинэчлэлтийн ажлыг байнгын ашиглалтад оруулах үйл ажиллагааг 2017 оны 08 дугаар сарын 02-ны дотор зохион байгуулахыг улсын комисс /Д.Буманбаяр/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ц.БАТ-ӨЛЗИЙ

D:/Захирамж/Эзэмшил/-2017-07-27 docx